

**Ардчилсан нийгэм дэх Монголын залуучуудын
улс төрийн оролцооны төлөв, хандлага**

Сэнгэдоржийн Мөнхбаатар

*Доктор (Ph.D)
МУИС-ийн Социологи,
нийгмийн ажлын тэнхим
Улаанбаатар, Монгол Улс
smunkhbaatar@gmail.com*

Батмөнхийн Пүрэвсүрэн*

*Магистрант
Шинжлэх Ухааны Академийн
Филофосийн хүрээлэн
Улаанбаатар, Монгол Улс
purevsuren_b@mas.ac.mn*

Хураангуй

1990-ээд оноос Монгол орон ардчилсан хөгжлийн замыг сонгосноор нийгэм, улс төрийн, онол баримтлалдаа үндсэн эргэлт хийх шаардлагатай тулгарсан. Ардчилсан нийгмийг төлөвшүүлэх зорилгоор түүнийг зөв чиглэлд хөгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гардаг. Үүний тулд иргэдийн улс төрийн оролцооны мөн чанар, түвшин, арга хэлбэр, төлөв хандлагыг танин мэдэх нь ач холбогдолтой. Тиймээс ч судлаачид залуучуудын нийгэм, улс төрийн идэвх, оролцооны онцлог, төлөв байдлыг гаргахдаа тухайн орны нийгэм, улс төрийн нөхцөл байдал, түүнд гарч буй эерэг сөрөг өөрчлөлттэй нь холбон судалж ирсэн. Залуучууд нийгмийн бие хүний хувьд тэдгээрийн төрж өссөн гэр бүл, олсон хүмүүжил, зан араншин, ертөнцийг үзэх үзэл санааны төлөвшил зэрэг хувь хүний шинж чанар зэргийг давхар харгалзан үзэх замаар судалсан байх нь олон.

Түлхүүр үгс: *монголын залуучууд, ардчилсан нийгэм, хандлага, төлөв, шинжилгээ*

* The Corresponding author



© The Author(s) 2023

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<https://orcid.org/0000-0003-0287-1347>

<https://orcid.org/0009-0006-8614-0654>

Received: 30 August 2023

Accepted: 20 October 2023

State and Trends in political participation of the young people in the democratic society

Munkhbaatar Sengedorj^{1*}

Doctor (Ph.D)
Department of Sociology and Social Work,
National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia
smunkhbaatar@gmail.com

Purevsuren Batmunkh²

MA candidate student
Institute of Philosophy, Mongolian Academy of
Sciences
Ulaanbaatar, Mongolia
purevsuren_b@mas.ac.mn

Abstract:

Mongolia has been following a democratic development path since the 1990s, facing the need to fundamentally change the concepts of society, politics, and theory. Since the development of a democratic society is the objective, it is natural to develop in the right direction. To do this, it is important to know the nature, level, method and attitude of citizen political participation. Consequently, the researchers explored the country's socio-political situation and changes in positive and negative socio-political situation in order to determine the characteristics and conditions of young people's social, political activities and participation. Young people are often studied as social members, taking into account their personal characteristics, such as their parents' birth and education, education, behaviour and the formation of worldviews.

Keywords: *Mongolian youth, democracy, democratic society, trends and state of democracy and analysis*

I. Оршил

Иргэдийн улс төрийн оролцоо нь орчин үеийн нийгмийн амьдралын чухал сэдэв бөгөөд улс төрийн засаглал, ардчилсан засаглал, засаглалын легитимт чанар хангагдах суурь нөхцөл болдог. Тиймээс ч уг асуудлыг олон талаас нь судлах шаардлага үүсдэг тул энэ талын судалгаа харьцангуй ховор биш. Гадаад болон дотоод олон судалгаа бий боловч ихэвчлэн улс төр судлалын судалгаа байх ба социологийн суурь хүчин зүйлсийг шинжилсэн, статистикийн нарийвчилсан шинжилгээ бүхий судалгаа ялангуяа дотоодод нэн хомс байна.

Бид энэхүү өгүүлэлдээ олон улсын болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгааны үр дүнг тоймлон шинжилж монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцооны өнөөгийн төлөв байдал хэтийн хандлагыг тодруулахыг зорьсон болно. Ингэхдээ нэгд, 2000 оноос хойш давтамжтай хийгдэж буй Азийн барометрийн ардчилал, засаглалын хөгжлийн судалгааны 5 дахь удаагийн судалгааны дүн, эрдэм шинжилгээний суурь судалгааны үр дүн, тайлангууд, бие даасан судлаачдын гүйцэтгэсэн судалгааны бүтээлүүд болон өөрийн орны залуучуудын улс төрийн оролцооны талаар хийгдсэн бэсрэг судалгаануудыг түлхүү ашигласан болно. Дээр дурдсан иргэдийн улс төрийн оролцоо, түүний хэлбэр, түүнд тулгамдсан асуудлын талаар тогтолцооны түвшинд судалсан судалгаа, эрдмийн ажлуудыг дараахь

байдлаар тоймлон авч үзсэний дээр залуу судлаачийн хувьд сонгон судалж буй сэдвийн хүрээнд шинийг эрэлхийлэн энэхүү өгүүллийг тэрлэсэн нь ийнхүү бидний хамтарсан өгүүлэл болон нийтлэгдэх тус судалгааны өгүүллийн үндэслэл болно.

Монгол дахь иргэдийн улс төрийн оролцоо өөрчлөлтийн талаар зэрэг горилж бичсэн Д.Загджавын диссертац (Д.Загджав. 2002)-ийн судалгааны хүрээнд ардчиллын хөгжил, иргэдийн улс төрийн оролцооны талаарх сонгодог хийгээд орчин үеийн онолуудыг харьцуулан судалж төрийн байгууллагуудын тогтолцооны төлөвшил ба иргэдийн улс төрийн хэлбэрүүдийн харилцан хамаарлыг улс төрийн шинжлэх ухааны үүднээс судалж онол, арга зүйн гол зарчмуудыг тодруулахыг зорьсон байна. Тэрээр эл нэгэн сэдэвт бүтээлдээ тухайн үеийн иргэдийн улс төрийн оролцоонд тулгамдаж байсан асуудлыг хөндөхийн зэрэгцээ иргэдийн улс төрийн оролцооны түүхэн хандлагыг хамруулан үзэхийг хичээсэн байна. Чингэхдээ 1990 оноос хойш манай улсад тогтолцооны цоо шинэ хэв маяг, төрийн байгууллагуудын шинэ хэлбэрүүд бүрэлдэн төлөвшиж байгааг тэмдэглээд зогсохгүй, шилжилтийн үеийн улс төрийн оролцооны үндсэн хэлбэрүүд, шалтгаан нөхцөл, зорилго, үр дүнг улс төрийн бодит үйл явцын өрнөлт, улс төрийн харилцааны субъектүүд болон төрийн байгууллагуудын төлөвшилтэй холбон шинжилж дүгнэсэн байна.

Тэгвэл, Конрад-Аденуаэр-Сангийн захиалгаар 2016 онд Удирдлагын академийн судлаачдын багийн гүйцэтгэсэн “Залуучуудын улс төрийн оролцоо 18-35 нас” судалгаагаар Монгол Улсын хүн ам төдийгүй сонгогчдын ихэнхийг бүрдүүлдэг залуучуудын (18-35 насныхан) улс төр, сонгуулийн оролцоо, сонгуулийн зан үйлийг судалж, дүн шинжилгээ хийхийг зорьжээ. Ингэхдээ судалгааны түүврийг баруун, төв, зүүн бүсийн Говь-Алтай, Хөвсгөл, Хэнтий аймгийг, нийслэлийн Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүргийг сонгон судалгааг гүйцэтгэжээ. Судалгааны эх олонлогийг Улсын бүртгэл, статистикийн газраас гаргасан хүн ам, өрхийн тооллогын 2013 оны статистик мэдээлэлд үндэслэн 18-35 насны залуучуудын тоогоор хязгаарлаж, 1051,4 мянган залуучуудыг хамруулсан байна. Тус судалгааны үр дүнг боловсруулах арга зүйдээ цуглуулсан мэдээллийг нийгмийн судалгааны тоон мэдээллийг боловсруулах SPSS багц программаар нэгтгэн, мэдээллийн харьцаа, харьцуулалт, корреляци, дундаж утга, хүчин зүйлийн шинжилгээг хийх үр дүнг боловсруулахаар дурдсан авч, судалгааны үр дүнд хүчин зүйлийн шинжилгээг ашиглаагүй байна. Нэмж хэлэхэд, судалгаанд залуучуудын улс төрийн оролцоог ерөнхийлөн дүгнэхдээ тухайн улс төрийн оролцооны хэлбэр тус бүрээр дүгнэсний зэрэгцээ улс төрийн оролцооны хэлбэр бүрээр ангилан үнэлэхэд залуучуудын 59 хувь нь “огт оролцдоггүй” ангилалд хамаарагдсан дүн гарчээ. Энэ бол залуучуудын сонгуулийн ирц, оролцоо хангалтгүй, шийдвэр гаргах түвшинд манлайлал хязгаарлагдмал байгааг илтгэхээс гадна тэдний хэрэгцээ, шаардлага, хүсэл тэмүүлэлд илүү анхаарал хандуулж, шийдвэрлэх арга замыг тодорхойлоход залуучуудын оролцоог хангах нэн шаардлагатай болсныг харуулна. Судалгааны дүгнэлтээс мөн 18-35 насны залуучуудын сонгуулийн оролцоо харьцангуй өндөр байгаа нь залуучуудын нас нэмэгдэх тусам ухамсартай, бие даасан сонголт хийх хандлага нэмэгдсэн дүр зураг ажиглагджээ. Энэ нь нэг талаас залуучуудын сонгуульд оролцохгүй байх шалгаан болсон *итгэл хүлээсэн нам, улс төрч байхгүй, улс төр сонирхдоггүй, сонгох нам улс төрч байхгүй, улс төрийн тогтолцоонд итгэхгүй* байгаатай шууд холбоотой гэсэн дүгнэлтийг гаргасан байна (Удирдлагын

академи 2016, 28).

Конрад-Аденуазэр-Сангийн захиалгаар Нийгэм улс төрийн боловсрол (НҮТББ)-ын гүйцэтгэсэн “Z үеийн залуучуудын улс төрийн оролцоо 17-26 нас” (2021) судалгаагаар үндэсний хэмжээнд нийслэл, орон нутгийн 17-26 насны 1161 залуучуудыг түүвэрлэн тус судалгааг гүйцэтгэсэн байна. Судалгааны үр дүнгээр залуучуудын улс төрийн оролцооны түгээмэл хэлбэр нь сонгуульд оролцож саналаа өгөх байдлаар илэрдгийг тодруулахын сацуу сонгуультай холбоотой мэдээлэл, сонгуулийн үр дүнг хамгийн их сонирхдог, улс төрийг ерөнхийд нь “заримдаа” сонирхож, оролцдог боловч бодит оролцоо нь хязгаарлагдмал төдийгүй өнөөгийн улс төрийг замбараагүй байна хэмээн үнэлсэн нь энэхүү дүгнэлтийг хийхэд хүргэв.

Тэгвэл, Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM)-гээс “Залуучуудын санал бодлын судалгаа”-г (2020) үндэсний хэмжээнд 18-40 насны иргэдийг түүвэрлэн гүйцэтгэжээ. Тус судалгааны үр дүнг боловсруулахдаа улс төрийн оролцооны хэлбэр, түвшин зэргийг нас, хүйс, боловсрол, бүс нутаг зэрэг үзүүлэлтэй харьцуулсан боловч хүчин зүйлийн болон хамаарлын шинжилгээг ашиглаагүй байна. Тухайн судалгааны хүрээнд залуучуудын ба эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны асуудлыг багтаан судалж, улмаар өөрийн улсын насанд хүрсэн хүн амын бүх гишүүд улс төрийн шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцооны хэлбэрийг тодруулахад 68% нь “*маш чухал*”, 26% нь “*чухал*”, 6% нь “*чухал биш/чухал биш*” гэж хариулсан нь улс төрийн амьдралд иргэд оролцох нь чухал гэсэн хандлага иргэдийн дунд нэгэнт бий болсныг илтгэж буй. Тодруулбал, 3 хүн тутмын нэг нь манай улсын улс төрийн амьдралд залуучуудын бүлэг оролцох нь чухал хэмээн хариулсан бол, 2 хүн тутмын нэг нь эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс оролцох нь чухал гэж үзсэн байна.

Улс төрийн академиас эрхлэн гаргасан “Шинэ толь-84” сэтгүүл (Уб., 2022)-д улс төр судлалын доктор О.Хатанболд “Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцооны талаарх ойлголт” сэдэвтэй нэгэн өгүүлэлдээ «... *нийгмийн анги, бүлэг, хүн ам зүйн янз бүрийн бүлэг, хэсэг давхрааны үйл байдал тус бүртээ харилцан адилгүй, онцлогтойгоор илэрч, бас хэрэгждэг*» хэмээн дурдсан байна. Тэрбээр мөн залуучууд бол нийгэм улс төрийн идэвхээр өвөрмөц онцлогтой нийгэм-хүн ам зүйн бүлгийн нэг мөн хэмээгээд энэ өвөрмөц бүлгийн улс төрийн идэвх, оролцооны түвшнийг дараахь байдлаар тодорхойлон авч үзжээ (О.Хатанболд 2022, 78-100).

	<p>Улс төрийн оролцоо, идэвхийн талаарх ойлголт</p>	<ul style="list-style-type: none"> • улс төрийн талаарх мэдлэг, сонирхол • ардчиллын талаарх залуучуудын ойлголт, гарч буй өөрчлөлт
	<p>Улс төрийн идэвх, оролцооны хэлбэрийг</p>	<ul style="list-style-type: none"> • улс төрийн идэвх, оролцоо • залуучуудын дэд соёл • бодлогын орчны өнөөгийн байдлаар тус тус тоймлон (авч үзсэн байна.)

Иргэдийн дуу хоолой тэр дундаа залуучуудын улс төрийн оролцооны талаарх үзүүлэлт хангалттай хэдий ч төр засгийн болон нутгийн удирдлагын шийдвэрт нөлөөлөх тал дээр хангалтгүй байгаа нь тодорхой харагддаг. Боллоцгоог нь хангавал ихэнх тохиолдолд хүмүүс өөрсдийгөө, шударга чөлөөтэйгөөр удирдан залах чадвартай гэж үздэг. Судалгааны үр дүнгээс гарсан гол үр дүнгүүдээс Ажил эрхлэлтийн байдал, мэргэжлийн онцлогоос шалтгаалж улс төрийн оролцоо, улс төрд оролцох боломж нь харилцан адилгүй байдаг ба энэ нь хувь хүний ажил эрхлэлт, мэргэжил түүний орлого нийгмийн хүрээг тодорхойлохын зэрэгцээ, тэдгээрийн мэргэжил нь боловсролын түвшинтэй уялддагтай холбоотой. Залуучуудын улс төрийн идэвх, оролцооны өнөөгийн байдалд хүчин төгөлдөр үйлчилж, бас мөрдөгдөж буй бодлогын орчин, нөхцөлтэй холбоотой асуудлыг тоймлон дараахь үндсэн гол гол дүгнэлтүүдийг гаргасан байна (О.Хатанболд 2022, 78-84).

1	Өнөөгийн Монголын залуучуудын талаар...	баримталж буй төрийн бодлогын иж бүрэн, цогц хандлага дутагдаж байна.	Одоо буй хандлагад орчин үеийн залуучуудын талаарх онцлогийг тусгах шаардлага хэрэгжихгүй байна.
2	Оролцооны зураглалын хувьд өнөөгийн монголын залуучуудын талаарх төрийн бодлогын хувьд иж бүрэн цогц хандлага дутагдаж байна. Үүнд, дараахь онцлогийг тусгасан боловч шаардлага хэрэгжихгүй байна.	а) Залуучуудын оролцоо, шууд ардчиллын үзэл санаа, эрчимтэй сэргэж байгаа ч эрх зүйн суурь орчинд дорвитой өөрчлөлт орсонгүй; б) Залуучууд оролцооны тухай асуудлыг гол төлөв, улс төрийн оролцоогоор төсөөлж, оролцооны бусад төрөл хэлбэрийг тэр бүр ойшоохгүй байна;	в) Улс төрд эмэгтэйчүүд, дээд боловсролтой, хотын залуус, илүү оролцож байгаа бол, олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд мөн дээд боловсролтой, эрэгтэйчүүд, орон нутгийн залуус өндөр хувьтай байна; г) Залуучуудын ажиллах хүчний оролцооны түвшин жигд биш байдал үргэлжилж байна.
3	Залуучуудын оролцоонд засаглалын институтэд итгэх итгэл хамгийн их нөлөө үзүүлж буй гол шалтгаан нь:	а) Засаглалын байгууллагуудын ажлын үр дүн амьдралд бодитоор мэдрэгдэхгүй, эдийн засгийн нөхцөл байдал тааруу, өр зээлийн асуудал, үнийн өсөлт амьжиргааны түвшин гм; б) Улс төрийн нам, улс төрчдөд итгэх итгэл буурч улмаар авлига буурна гэдэгт итгэхээ больсон;	в) Залуучуудын оролцоонд ОНМХ хүчтэй нөлөөлж (<i>мэдээллийн гол эх сурвалж нь интернэт, сонин хэвлэл, энтертайнмент болон нийгмийн сүлжээний мэдээ, мэдээлэл болж</i>) байна; г) Орчин үеийн мэдээллийн хэт их ачаалал нь залуучуудын ажил хэрэгч хандлагыг эрс багасгаж, оролцооны идэвхийг сулруулж байна.

Баруун Европын улс төр, засгийн газар, төрийн бодлогын талаар болон Европын холбооны болон үндэсний сонгуулийн тухай мэдээллүүдийг нийтэлдэг “Баруун Европын Улс төр/West European Politics” сэтгүүлд Нидерландын Ниймеген, Радбудын их сургуулийн Социологийн тэнхим профессор Тимен Жеронсе, Нилс Спирингс нар “Улс төрийн оролцооны дүр зураг/Political participation profiles” (Thijmen Jeroense & Niels Spiering., 2023, 2-3) сэдэвт судалгааны өгүүллийг хэвлүүлсэн байна. Тус өгүүлэлд улс төрийн оролцоог

бүрдүүлж буй улс төрийн оролцооны дүр зургийг улс төрийн сэдэл, эх сурвалжтай холбон судлахыг зорьсон байна. Тухайлбал, тогтолцоонд итгэж байгаа учраас зорилгодоо хүрэхийн тулд магадгүй сонгуулийн тогтолцоонд илүү оролцох хандлагатай байж болно. Нөгөөтээгүүр, үл итгэлцлээс болж системээс гадуур оролцож болох үл итгэх байдал нь эсэргүүцлийн жагсаал, сонгуулийн оролцоог хослуулан системийн өөрчлөлтийг бий болгохтой тулгардаг. Ингэснээр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр улс төрийн идэвхтэй байх, сонгуулийн санал өгөх зэрэг нь харилцан адилгүй байр сууртинаас хандах явдал нийтлэг байдаг хэмээн тайлбарлахад хүргэнэ. Тэгвэл нийгмийн сүлжээний хэрэглээ нь намтай холбоотой байж болохоос гадна системийн гажуудалтай тэмцэх хэрэгсэл болж ч болно. Энэ тохиодолд парламентын сонгуульд санал өгөх нь илүү том репертуар (иж бүрдэл)-аас ялгаатай нь хэн нэгний цорын ганц улс төрийн үйлдэл юм хэмээн үзэхүл энэ өөр үр дагавартай. Түүнээс гадна маш үнэ цэнэтэй боловч улс төрийн тодорхой үйлдлүүдийг (индекс гм) тайлбарласан эсхүү тэдгээрийг хооронд нь холбосон байдлаар бусдад нөлөөлөх нь хялбар. Судлаачид энэхүү судалгаандаа дараахь хоёр асуултад хариулт олохыг зорьсон байна: (i) *Бид ямар өөр улс төрийн оролцооны профайлыг тодорхойлж чадах вэ?*; (ii) *Янз бүрийн эх сурвалж, улс төрийн сэдэл нь иргэдийн оролцооны профайлыг хэр зэрэг тайлбарлаж чадах вэ?*. Үүнээс үзвэл, орчин үеийн ардчилсан орнуудад улс төрийн оролцооны хэлбэр, шалтгаан, үр дагаврыг илүү сайн ойлгоход туслах улс төрийн оролцооны талаарх ирээдүйн судалгааны эхний алхам, шинийг эрэлхийлсэн уриалга болохыг илтгэнэ.

Энэхүү оршилд өгүүлсэн судалгааны тойм нь нэг талаараа иргэдийн улс төрийн оролцооны гол бэрхшээлтэй асуудлуудыг хөндөн тайлбарлахыг хичээсэн болно. Нөгөө талаар иргэдийн улс төрийн оролцооны бэрхшээлтэй асуудал нь иргэдийн боловсрол, мэдлэг, мэдээллээр дутагдалтай байдал, нийгэм-эдийн засгийн хямрал зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой болох нь бидний тоймлон үзсэн судалгааны үр дүнгүүд харуулав. Иймээс иргэдийн улс төрийн оролцоог боловсронгуй болгоход нэг талаас түүнд нөлөөлж буй хүчин зүйлс тухайлбал, нийгэм, улс төр, эрх зүй, эдийн засаг зэргийг, мөн түүнд нөлөөлж буй хүндрэл, бэрхшээлийг тухайлан судлах хэрэгтэйг илтгэнэ.

II. Судалгааны арга зүй

Өгүүлэлд түүхэн ба логик шинжилгээ, харьцуулсан арга зүй, баримтын шинжилгээ, норматив-үнэлэмжийн болон танин мэдэхүйн аргуудыг ашиглав. Ингэхдээ сүүлийн жилүүдэд хийгдсэн олон нийтийн санаа бодлын судалгаа, нийгмийн сэтгэл зүйн нөхцөл байдлыг голлон анхаарахын зэрэгцээ хувь судлаачид, судалгааны байгууллагуудын гүйцэтгэсэн судалгаанд улс төрийн социологийн шинжилгээнд тулгуурлан нөхцөл байдлыг тоймлон гаргахыг хичээсэн болно. Өөрөөр хэлбэл, нийгмийн сэтгэл зүйн чиг хандлага нь хувь хүний үзэл хийгээд түүнээс үл хамаарах зүй тогтлыг олонхын санаа бодолд тохирсон хандлага нийгэмд хэрхэн тогтсоныг илрүүлэхийг зорьсноороо онцлогтой.

III. Судалгааны үр дүн

Оролцоо бол ардчиллын оршихуйн амин сүнс, үндсэн суурь нь болдог учраас

орчин үед улс төр судлаачид улс төр дэх иргэдийн бодит оролцооны шинж байдалд суурилан оролцоог ардчилсан дэглэмийг бусад дэглэмүүдээс ялгаж үзэх гол шалгуур хэмжүүрийн түвшинд онцолж үзэх болсон. Ардчилал болон дарангуйллын үед хүмүүсийн амьдрах үндсэн ялгаа нь юунд орших вэ гэвэл ардчиллын үед хүмүүс нээлттэй, ул суурьтай, ухаалаг байхыг хүсдэгт байгаа юм. Тийм боломж нөхцөл нь ч хангагдсан байдаг. Харин дарангуйллын үед энэ бүхэн нь хэлбэр төдий байдаг. Тэгэхлээр ардчилсан нийгэм бол шударга хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан, бүх иргэдийнхээ эрх, эрх чөлөөг дэмжин хамгаалдаг, нээлттэй ил тод, хүлээн зөвшөөрөгдсөн, эрх зүйн хэм хэмжээтэй, хариуцлагын зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулах бүх боломж бүрдсэн нийгэм юм (О.Хатанболд. 2015, 233). Харин 1990 оноос хойш иргэдийн улс төрийн оролцоо бүрэн утгаараа хэрэгжих боломжтой болсон хэмээн үзвэл дараахь нөхцөл байдал бодитоор нөлөөлү явагдсан гэж болно. Тодруулбал, 1921-1990 он хүртэлх иргэдийн улс төрийн оролцоо нь Үндсэн хуульд бэлгэдэл төдий нэг намын үзэл суртал, уламжлалт зан үйлийн хүчин зүйлсийн нөлөөн дор идэвхгүй байдлаар оршин байсан. Харин 1990 оны ардчилсан хувьсгал нь иргэдийн улс төрийн оролцоо үндсэн утгаараа хэрэгжих боломжтой болж иргэдийн мэдлэг ухамсарт эргэлт болж чадсан. Гэвч бид ардчилсан тогтолцоонд шилжин иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг тунхаглаад 20 гаруй жил болсон боловч уламжлалт сэтгэлгээ улс төрд тодорхой хэмжээгээр хадгалагдсаар байгаа талаар судлаачид онцлон тэмдэглэсэн байдаг (Г.Чулуунбаатар, Д.Баасансүрэн ба бусад 2017, 67-69).

Тэгвэл, өнөөдөр Монголын залуучуудын улс төрийн оролцоо сул байгаатай холбогдуулан төр-иргэний хооронд үзэл бодлын ялгаатай төсөөлөл хэлэлцүүлэг өрнөдөг. Энэ нь зарим талаар тодорхой зүйлстэй холбогддог гэж болно. Тухайлбал, бид бүхэн өмнө нь улс төрийн оролцоог сонгуулийн компани ажил явагдах үеэр сонгуульд нэр дэвших, оролцох зэргээр төсөөлдөг байсан бол энэ нь одоо илүү гүнзгийрч төрөл, хэлбэрийн хувьд цар хүрээгээ үлэмж тэлсээр байна.

1990-ээд оноос Монгол орон ардчилсан хөгжлийн замыг сонгосноор нийгэм, улс төрийн, онол, үзэл баримтлалдаа суурь эргэлт хийх шаардлагатай тулгарсан нь нэг талаас ардчилсан нийгмийг төлөвшүүлэх зорилгыг тавьсан болохоор түүнийгээ зөв чиглэлд хөгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарах зүй тогтол юм. Үүний тулд иргэдийн улс төрийн оролцооны мөн чанар, түвшин, арга хэлбэр, төлөв хандлагыг нь танин мэдэх нь чухал ач холбогдолтой. Нийгмийн амьдралын хамгийн хөдөлгөөнтэй хувьсамтгай тал нь улс төрийн хүрээ байдаг бол, хүн ам зүйн хувьд тийм хөдөлгөөн ихтэй, өөрчлөмтгий хэсэг нь залуучууд юм. Залуучууд бол нийгэм улс төрийн идэвх, оролцооны хувьд өвөрмөц онцлогтой нийгмийн хүн ам зүйн бүлэг. Тиймээс залуучуудын улс төрийн оролцооны асуудлыг судлах явдал туйлын чухал болох нь жил ирэх тусам мэдрэгдэж, бас харагдаж байна.

Залуучуудын улс төрийн оролцоонд хувь хүнээс үл шалтгаалах улс төр, нийгэм эдийн засгийн системийн буюу макро түвшний хүчин зүйлс мөн давхар нөлөөлдөг. Жишээлбэл, сонгуулийн мажоритар тогтолцоо залуучуудын сонгуулийн ирцэд сөргөөр нөлөөлдөг байх магадлалтай. Уг тогтолцоо нь залуу нэр дэвшигчдэд халтай байдаг учраас залуучууд сонгуульд тэр бүр нэр дэвшдэггүй. Залуучууд нэр дэвшихгүй байх нь эргээд залуу сонгогчдын ирцэд сөргөөр нөлөөлөх үндэслэл болдог. Учир нь залуу нэр дэвшигчид сонгуульд олноороо оролцвол залуу

сонгогчид идэвхтэй санал өгдөг юм. Залуучуудын улс төрийн оролцоонд тэдний боловсролын чанар, нийгмийн гарал үүсэл, болон гэр бүлийн гишүүдийн тэр тусмаа эцэг, эхийн нөлөө чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг хэд хэдэн судалгаа баталсан байдаг. Тухайлбал, урт хугацааны туршид хийсэн судалгаанаас харахад бага, дунд, ерөнхий боловсролын сургуульд сурч байх хугацаандаа иргэний оролцоо, улс төр, сонгууль, ардчиллын талаар хичээл, сургалтад хамаарагдаж байсан хүүхдүүд насанд хүрсний дараа сонгуульд санал өгөх, сайн дурын ажил хийх, улс төрд идэвхтэй оролцох магадлал илүү байдаг байна. Мөн чинээлэг айлын хүүхдүүд илүү улс төрд сонирхолтой байхын сацуу сонгуульд санал өгөх магадлал нь өндөр байдаг ажээ.

Залуучуудын дунд хийсэн судалгаануудаас үзэхэд дээрх ерөнхий арга зүйг чанд баримталж ирсэн байдаг. Тухайлбал, 1990 оноос өмнөх үеийн залуучуудын нийгэм, улс төрийн оролцооны хэлбэрийн талаас нь тоон үзүүлэлтээр бус харин агуулга мөн чанараар нь авч үзвэл: манай оронд олон арван жилийн турш явцуу хүрээ, нэг хэв загвараар хязгаарлагдаж байсан нь тодорхой харагдана (С.Мөнхбат, Б.Бат-Эрдэнэ, 2022, 178-185). Тиймдээ ч улс төрийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн оролцоо улс орон бүхэнд нэгэн ижил түвшинд байдаггүй. Учир нь улс төрийн ямар дэглэмтэй байгаагаас хамааран улс төрийн засаглал хэрхэн хэрэгжиж, бас хүн амын амьдралын түвшин ямар байгаа зэргээс шалтгаалж хувьсамтгай хийгээд байнгын хөдөлгөөнтэй байж болдог (Д.Загджав. 2002). Тухайлбал, өнөөгийн байдлаар манай улсад иргэд засгийн газрыг шүүмжилж, тэр ч бүү хэл огцрохыг шаардаж жагсаал цуглаан хийх эсвэл өөр олон төрлийн “activist” хөдөлгөөнүүдийг өрнүүлдэг, бас өрнүүлсээр ирсэн. Чингэх нь аль ч талаасаа аваад үзсэн манайд нийцтэй оролцоонд тооцогдох үйл ажиллагааг явагдсаар ирсэн хэмээн дүгнэж болохоор байна. Үүнийг дараахь хүснэгтээс дэлгэрүүлэн харж болохоор байна.

Хүснэгт 1. Залуучуудын улс төрийн оролцоо (2016 оны сонгуулийн дүн)

Илэрхийлэмж	18-20 нас	21-25 нас	26-30 нас	31-35 нас
Байнга оролцдог	5.1%	7.2%	8.3%	7.6%
Зарим үед оролцдог	47.1%	59.6%	61.0%	56.5%
Огт оролцдоггүй	47.8%	33.2%	30.7%	35.9%
Нийт	100%	100%	100%	100%

Дээрх хүснэгтээс 2016 онд Монгол залуучуудын улс төрийн оролцооны түвшин хангалтгүй байгааг харж болно (Удирдлагын академи 2016).

Бид судалгааны үр дүнд хийсэн шинжилгээг хэлэлцүүлэг хэсэгтээ дараахь байдлаар дэлгэрэнгүй тайлбарласан болно.

IV. Хэлэлцүүлэг

Нийгмийн ардчилсан тогтолцоо, чөлөөт зах зээлийн хөгжлийн явцаар иргэдийн ахуй амьдрал төр засаг, улс төрчдөөс хамаарах байдал аажмаар багасаж, харин өөрсдийнх нь идэвх санаачилга, хүчин чармайлтаас илүү хамаарах байдал удаан боловч нэмэгддэг жамтай. Ийм үзэл баримтлал ардчилсан Үндсэн хуулийн үзэл

баримтлалд тусгалаа олсон байдаг. 1992 оны Монгол Улсын шинэ Үндсэн хуульд энэ үзэл санаа бодлого, эрх зүйн хувьд бүрэн баталгаажсан гэж үзэж болно. Гийм учраас, Үндсэн хууль, түүний хэрэгжилт иргэдийн амьдрал ахуйд хэрхэн нөлөөлж буйг шинжлэн судлах байнгын тогтмол, давталттай судалгааг явуулснаар ард түмний ардчилсан хууль ёсыг дээдлэх, ойлгох тухай эерэг, сөрөг хандлага, нөхцөл шалтгааныг тодруулснаар ардчиллын бодит дэмжлэг хэрхэн өсөж, буурч байгаа талаарх илэрхийлэмжийг олж тогтоох (О.Хатанболд 2016, 112-113) нь чухал ажээ.

Ардчилал хөгжихөд нийгмийн тэгш бус байдал, шударга бус явдал, авлига, ажилгүйдэл, ядуурал, архидалт, хэт их улстөржилд, хэнээрхэл, ёс суртахууны доголдол зэрэг бусармаг явдлууд газар авсны дээр иргэдийн боловсрол, улс төрийн болон ардчиллын соёлын төвшин доогуур байгаа нь үүнд нөлөөлж буй гол хүчин зүйлс болж байна. Гиймээс ардчиллын үнэлэмжийг дээшлүүлэхийг хүсвэл, бид нэн тэргүүнд дээр дурдсан сөрөг хүчин зүйлсийг арилгах, мөн үүнийг бууруулахад төр засаг, улс төрийн намуудаас популист бус дорвитой, ажил хэрэгч арга хэмжээ авч иргэдэд ардчиллын талаарх суурь мэдлэг, боловсролыг олгох явдал туйлын чухал байна.

Судлаачдын хувьд залуучуудын нийгэм, улс төрийн идэвх, оролцооны онцлог, төлөв байдлыг гаргахдаа тухайн орны нийгэм, улс төрийн нөхцөл байдал, түүнд гарч буй эерэг, сөрөг өөрчлөлттэй нь холбон судалж ирсэн. Залуучууд нийгмийн бие хүний хувьд тэдгээрийн төрж өссөн орчин, гэр бүлийн хүмүүжил, зан араншин, ертөнцийг үзэх үзэл санааны төлөвшил зэрэг хувь хүний шинж чанар зэргийг давхар харгалзан үзэх замаар судалсан байх нь олон.

Дээр дурдсан үр дүнгүүдийг нэгтгэн дүгнэх байдлаар монголын залуучуудын улс төрийн өнөөгийн оролцоог дараахь хэд хэдэн зүйлд ангилан үзэж, тодорхой саналыг дэвшүүлэхийг бид зорив.

Залуучууд ба сонгуулийн ирц: Сонгуульд санал өгөх нь улс төрийн уламжлалт оролцооны хамгийн чухал хэлбэр атал өнөөгийн монголын залуучуудын сонгуулийн ирц бусад насны бүлгүүдээс хамгийн бага байсаар ирсэн гэж болно. Ялангуяа 18-25 насны залуучуудын ирц өмнөх жилүүдэд тун хангалтгүй байсныг энд дурдах нь зүйтэй болов уу. Жишээлбэл, 2012 оны УИХ-ын сонгуульд тэдний ердөө 38%, 2016 оны сонгуульд 50% нь тус тус санал өгсөн байдаг. 2016 онд “Хамтын нөхөрлөлийн орнууд” байгууллагаас Залуучуудын хөгжлийн индексийг эрхлэн гаргажээ. Чингэхэд уг индексээр тооцон гаргасан улс төрийн оролцооны үнэлгээгээр манай улс дэлхийн дунджаас доогуур үнэлэгдэж 183 улсаас 105 дугаар байрт эрэмбэлэгджээ. Үүнд манай залуучуудын сонгуулийн ирц хангалтгүй байсан нь нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ сүүлийн жилүүдэд манай залуучуудын улс төрийн идэвх илт сайжирч байгааг өнгөрсөн 2020 оны УИХ-ын сонгуулиар бид бүхэн бэлхнээ харсан. Тус удаагийн сонгуулиар 18-25 насны залуучуудын 63% нь санал өгч өмнөх жилүүдэд байгаагүй өндөр ирцтэй оролцсон бол, мөн оны 10 дугаар сард орон нутгийн ИТХ-ын сонгуульд дээрх насны залуучуудын ойролцоогоор 37.4% нь санал өгсөн байна. Энэ нь өмнөх удаагийн орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчдийг сонгох сонгуулийн ирцээс 4.8%-аар өссөн байгаа нь олзуурхууштай.

Тэгвэл, залуучуудын сонгуулийн ирц дэлхий дахинд ямар түвшинд байдаг талаар олон улсад хийгдсэн судалгаануудаас харахад, 1970-аад оноос хойш дэлхийн бараг бүх ардчилсан улсад сонгуулийн ирц буурсаар буй ерөнхий дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал, 2019 оны байдлаар “Freedom House” байгууллагаас ардчилсан гэж үнэлэгдэж буй улс орнуудад хамгийн сүүлд зохион байгуулсан сонгуулийн ирцийг тухайн улсын хамгийн анхны эсвэл 1970-аад онд хийсэн сонгуулийн ирцтэй нь харьцуулж үзэхэд дийлэнхийнх нь ирц буурсан байна. Монгол Улсын хувьд 1992 оны анхны ардчилсан сонгуулийн ирц нь 98% байсан бол, 2020 онд 73% болж даруй 25%-аар буурсан байдаг.

Залуучууд ба улс төрийн нам: Улс төрийн уламжлалт оролцооны өөр нэг хэлбэр нь намд гишүүнээр элсэж, намын үйл ажиллагаагаар дамжин улс төрд нөлөөлөх явдал билээ. Харамсалтай нь энэ талын оролцооны талаар харьцуулсан дата, мэдээлэл тун ховор байна. Гэхдээ «Global Barometer Surveys» хэмээх олон улсад хийгдсэн судалгааны мэдээллийг ашиглаж дэлхий дахинд залуучуудын хэдэн хувь нь аливаа нэг намыг дэмждэг эсэхийг мэдэж болох юм. Намыг дэмждэг залуучууд тухайн намд гишүүнээр элсэх магадлалтай учраас шууд бус утгаараа энэхүү үзүүлэлт нь дээрх улс төрийн оролцоог илэрхийлэх бүрэн боломжтой.

Энэхүү судалгаанд оролцсон дэлхийн 89 орны 30 хүртэлх насны 45,191 залуучуудаас «*Та аль нэг намыг дэмждэг үү?*» гэж асуухад тэдний 48% нь “*дэмждэг нам бий*” гэж хариулжээ. Иймд дэлхий дахинд дунджаар 2 залуу хүн тутмын нэг нь намыг дэмждэг гэж хэлж болохоор байна. Уг үзүүлэлтээр Малави улс тэргүүлж Перу хамгийн сүүлд бичигдэж байна. Малави улсын залуучуудын 72% нь дэмждэг нам бий гэж хариулсан бол, Перу улсын залуучуудын 82% нь тийм нам байхгүй гэжээ. Харин Монголын залуучуудын хувьд 2020 оны 11-12 дугаар сард хийсэн “Сонгуулийн дараахь судалгаа”-д оролцсон 30 хүртэлх насны залуучуудын 34% нь «*аливаа нэг намыг дэмждэг*» гэж хариулсан бөгөөд энэ нь дэлхийн дунджаас 14%-аар бага байна (Globalbarometer 2023).

Залуучуудын улс төрийн сонирхол: Залуучууд бүх төрлийн улс төрийн оролцоонд нөлөөлдөг чухал хувьсагчдын нэг нь улс төрийг сонирхох явдал юм. Улс төр сонирхдог залуучууд сонгуульд санал өгөх, намд гишүүнээр элсэх, жагсаал цуглаанд оролцох, бусдыг улс төрд татан оролцуулах магадлал өндөр байдаг нь олон судалгаагаар батлагддаг. Тэгвэл «Global Barometer Surveys» буюу Дэлхийн үнэлэмжийн судалгаа (World Values Survey)-нд оролцсон дэлхийн 121 улсын 30 хүртэлх насны залуучуудаас «*Та улс төрийг сонирхдог уу?*» гэж асуухад тэдний ойролцоогоор 42% нь сонирхдог, 58% нь сонирхдоггүй гэж хариулжээ. Уг үзүүлэлтээр Мьянмар улс дэлхийд тэргүүлсэн бол, Румын хамгийн сүүлийн байрыг эзэлж байна. Мьянмарын залуучуудын 81% нь улс төр сонирхдог бол, Румын улсын залуучуудын ердөө 18% нь ижил хариулт өгсөн байна. Харин монголын залуучуудын 40% «улс төр сонирхдог» гэж хариулсан байна. Энэ нь дэлхийн дунджаас үл ялиг бага байна.

Залуучууд өөрсдийн амьдарч буй орон нутгийнхаа асуудалд шийдэл эрэлхийлдэг эсэх: Залуучуудын өөрсдийн амьдарч буй орчин, хүрээлэл, орон нутагтаа тулгамдаж буй аливаа нийгэм, эдийн засгийн асуудлуудыг иргэд өөрсдөө гаргаж ирдэг. Улмаар өөр хоорондоо хамтран нэгдэж шийдэл хайх нь улс төрийн

«институтийн бус» оролцооны нэг чухал хэлбэр юм. Тиймээс өөрсдийн амьдарч буй хороо, дүүрэг, хотдоо байгаа асуудлуудаа орон нутгийн ИТХ, Засаг даргадаа уламжилж, тухайн жилийн төсөвт холбогдох зардлыг суулгуулж, шийдүүлэхэд иргэд бидний өөрсдийн оролцоо нэн чухал гэдгийг “Өглөө” төслийн зүгээс онцлон сануулж Шийдэл-Өглөө аяныг зохион байгуулж байсныг энд цухас дурдах нь зүйтэй санагдав.

Тэгвэл, иргэдийн улс төрийн энэхүү оролцооны түвшин дэлхий дахинд хэр байгааг дараахь байдлаар товч танилцуулъя. Бидний дээр дурдсан «*Global Barometer Surveys*» судалгаанд оролцсон 30 хүртэлх насны залуучуудаас «Та өмнө нь бусадтай нийлж амьдарч буй орон нутгийнхаа асуудлыг гаргаж ирж, шийдвэрлэх гэж оролдож байсан уу?» гэж асуухад тэдний 27.4% нь «тийм, оролдож байсан» гэж хариулсан байна. Тус үзүүлэлтээр Малави улсын залуучууд дэлхийд тэргүүлж, Өмнөд Солонгосын залуучууд хамгийн сүүлийн байранд оржээ. Харин Монгол залуучуудын ойролцоогоор 27% нь амьдарч буй орон нутгийнхаас асуудлыг шийдэх гэж оролдож байсан гэж хариулсан нь дэлхийн дундажтай ойролцоо байв (С.Болдсайхан 2021).

Залуучуудын эсэргүүцлийн жагсаал: 1960-аад оны сүүлч 1970-аад оноос барууны орнуудад янз бүрийн агуулгатай эсэргүүцлийн хөдөлгөөн эрчимжсэн. Эдгээр үзэгдэл нь улс төр социологийн шинжлэх ухааны хандлагуудыг нэгтгэх, ялангуяа улс төрийн социологийн салбар шинжлэх ухааны хөгжлийг түргэтгэсэн юм. Эсэргүүцлийн хөдөлгөөнүүд нь баялгийн хуваарилалт, иргэний эрхийн болон энх тайвны төлөөх олон агуулгаар засгийн газарт шахалт үзүүлэхийн тулд нөөцийг дайчилсаар ирсэн нь нийгмийн улс төрийн үзэгдэл юм. Энэ үйл явц нь улс төрийн социологийн хүрээнд хөдөлгөөний тухай нөөцийн дайчилгааны онол болон “*Улс төрийн процессын загвар*”-ыг тогтвортой байршуулсантай шууд холбогдоно. Нэг үгээр бол, үзэл санааны өөрчлөлтийг даган жижиг дайчилгааны үйл явц улс төрийн өргөн хүрээтэй орчин хамардгийг хөдөлгөөний дотоод байгуулалтаас харагддаг болохын илрэл бөлгөө. Улс төрийн үйл явцын онол нь маргаантай сэтгэгдлээс үүссэн эсэргүүцлийн мөчлөгийн үед улс төрийн боломжуудыг онцлон нийгмийн хөдөлгөөний дайчлах онолын дагуу бүтцийг дайчлан үйл явцын хүрээг тэлдэг (Ц.Батболд 2018).

Эсэргүүцэл бол ардчиллын нэгэн шалгуур гэж үздэг. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ард иргэд аливаа асуудлыг шийдвэрлэхэд оролцох эрхэм зарчмыг сахин хамгаалахын тулд үндсэн асуудлаар нэг саналтай байж, аль аль талдаа хүндэтгэх явдал чухал гэдгийг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, ард иргэдийг улс төрийн үйл амьдралд албадан оролцуулах ёсгүй, харин ч түүнд оролцохгүйгээр өөрсдийн дургуйцлийг илэрхийлэх эрх чөлөөтэй байх явдал мөн бөгөөд ард иргэдийн идэвхтэй оролцоо дутагдвал ардчилал доройтон сулардаг (О.Хатанболд 2017, 47) ажээ.

Энх тайван ч байдлаар эсэргүүцлийн жагсаалд оролцох нь иргэдийн улс төрийн оролцооны хүлээн зөвшөөрөгдсөн хэлбэр мөн бөгөөд нийгмийн томоохон өөрчлөлт, шинэчлэлийг залуучууд эсэргүүцлийн жагсаалаар хийсэн жишээ дэлхийн түүхэнд олон бий. Тухайлбал, Сербийн дарангуйлагч Слободан Милошевичийг 2000 онд залуучуудаар манлайлуулсан “Отпор хөдөлгөөн” эсэргүүцлийн жагсаал зохион байгуулж байж эрх мэдлээс нь огцруулсан. Түүнээс хоёр жилийн өмнө

Чили улсын залуучууд эдийн засгийн тэгш бус байдлыг эсэргүүцэж улс даяараа эсэргүүцлийн жагсаал хийж байж үндсэн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулж, эдийн засгийн томоохон шинэчлэлийг эхлүүлж чаджээ. Бидний сайн мэдэх Хонг Конгийн залуучууд ардчилал, эрх чөлөөний төлөө сүүлийн жилүүдэд тасралтгүй тэмцэж байгаа. Мөн саяхнаас манай хойд хөршийн залуучууд түүнтэй төстэй тэмцлийг эхлүүлээд байна. Тодруулбал, оросын залуучуудын хувьд засаглал цөөнхийн саналыг харгалзан үзэхийг хуулиар баталгаатай болгох (40%), түүний “зөөлөн” хэлбэрээс эхлээд хувь хүний үйл хөдлөлийн бүрэн чөлөөт байдлын баталгааг хангах хүртэл (15%) бүхэлдээ ардчилалд татагдах явдал онцлог шинж нь болж буйг харуулсан. Мөн сөрөг хүчнийг болон сонгуулийг хориглогч жинхэнэ диктатурын талынхны хувь хамгийн бага буюу 4 хувь, сөрөг хүчний үйл ажиллагааг болон сонгуульд оролцох түүний оролцоог төрөөс хязгаарлах талынхны хувь хангалттай өндөр (28%)-тай байна (Г.Чулуунбаатар, А.С.Железняков ба бусад 2017, 136-137). Үүнээс харвал, залуучууд эсэргүүцлийн жагсаалаар нийгмийн томоохон өөрчлөлтийг хийж байсан жишээ манай түүхэнд ч бий. 1990-ээд оны эхэн үеийн 30 хүртэлх насны залуучууд нэг намын тогтолцооны эсрэг эвлэлдэн нэгдэж, эсэргүүцлийн жагсаал зохион байгуулж, олон нийтийг удирдан манлайлж чадсаны үр дүнд ардчилсан хувьсгал Монголд амжилттай өрнөсөн билээ.

Тэгвэл, «*Global Barometer Surveys*» судалгаанд оролцсон олон улсын 30 хүртэлх насны залуучуудаас «*Та өмнө нь эсэргүүцлийн жагсаалд оролцож байсан уу?*» гэж асуухад 11% нь “тийм” гэж хариулсан байна. Уг үзүүлэлтээс харахад, Пакистан улсын залуучууд дэлхийд тэргүүлсэн бол Өмнөд Солонгосын залуучууд хамгийн сүүлд орж байна. Харин тус судалгаанд оролцсон монгол залуучуудын 18% нь эсэргүүцлийн жагсаалд оролцож байсан гэж хариулжээ. Энэ нь дэлхийн дунджаас 7%-аар илүү байв (С.Болдсайхан 2021).

V. Дүгнэлт

Дээр дурдсан нөхцөл байдлыг Азийн барометрийн 2012 онд хийсэн судалгааны үр дүнд Зүүн Өмнөд Ази дахь залуучуудын улс төрийн оролцоо, ардчилсан засаглал, ардчиллын талаарх залуучуудын хандлагыг бүс нутгийн хэмжээнд шинжлэн үзвэл дараахь дүр зураг ажиглагдсан болно. Зүүн Азийн 13 оронд хийгдсэн тус судалгааны дүнгээс залуу үеийнхний дийлэнх нь ардчилалд сэтгэл хангалуун байдаг гэсэн зураглал гарчээ. Судалгаанд хамрагсдын дийлэнх нь ардчилсан дэглэмтэй адилтгах өөр ямар нэг улс төрийн тогтолцоо “үгүй” гэж хариулсан бол, тухайн бүс нутаг дахь буурай хөгжилтэй улс орнуудад дийлэнх хувь нь ардчиллыг эрхэмлэх түвшин өндөр гарчээ. Харин Япон, Өмнөд Солонгос зэрэг өндөр хөгжилтэй орнуудын залуучууд ардчиллыг эрхэмлэх хандлага харьцангуй бага түвшинд байна (UNDP 2013, 57-58). Тэгвэл Монголын залуучуудын хувьд тэдний 45% нь ардчиллыг дэмжсэн байхад, 39.1% нь авторитар засаглалыг дэмжсэн байна (УТБА 2012). Хэдийгээр ардчиллын талаар залуучууд ийм хандлагатай байгаа ч ардчиллыг дэмжигчид засаглалын бусад дэглэмийг дэмжигчдээс 7 дахин их байгаа нь судалгааны дүнгээс харагдлаа. Тус судалгаагаар Зүүн Азийн орнуудын залуу үеийнхний дийлэнх нь ардчилалд сэтгэл хангалуун байдаг хэмээн үзсэн бөгөөд тэдний хувьд түүнтэй адилтгах өөр ямар нэг тогтолцоо “үгүй” гэж хариулжээ. Өмнөх сэдвийн хүрээнд хөндөх дараагийн асуудал бол ардчиллын тухай монголчуудын ойлголт төсөөлөл, түүний

хувьсгал өөрчлөлтийг судлах асуудал юм. Монголчуудын дийлэнх нь ардчилал бол улс төрийн системийн “идеал” гэсэн ерөнхий ойлголттой байсаар ирсэн. Гэхдээ 2003, 2006 онд Монгол Улсад хийгдсэн Азийн барометрийн судалгаагаар хүн амын 91-94 хувь нь ардчиллын төлөө байдгаа илэрхийлэхийн зэрэгцээ 61.2 хувь нь манайд тогтсон ардчилал хэрэгжиж буй байдалд сэтгэл нийцэж байна, 58.2 хувь нь бага зэргийн асуудал байгаа ч “Монгол Улс ардчилалтай” гэж тус тус үзсэнийг энд дурдахгүй өнгөрч боломгүй санагдана. Эндээс бидний өнөөдрийн засаглал хэр ардчилсан байгааг 10 баллын шкал хэрэглэн хэмжихэд 6.6 (2003), 6.7 (2006) оноогоор үнэлжээ (Д.Ганбат 2010). Энэ бол ардчиллыг субстантив, идеал утгаар ойлгосон төсөөллийн зураглал гэж үзэж болох бөгөөд эл зураглал одоо ч хэвээр байгааг гэрчилж буйн илрэл хэмээн олон судлаачид (О.Хатанболд 2017, 80-82) дүгнэсэн байдаг.

Үүнээс нэгтгэн дүгнэвэл, залуучуудын улс төрийн оролцоонд хувь хүнээс үл шалтгаалах улс төр, нийгэм эдийн засгийн системийн буюу макро түвшний хүчин зүйлс давхар нөлөөлдөг байна. Тухайлбал, сонгуулийн мажоритар тогтолцоо залуучуудын сонгуулийн ирцэд сөргөөр нөлөөлөх магадлал өндөртэй байдгийг дээрх судалгааны үр дүн харуулж байна. Эндээс тухайн тогтолцоо нь залуу нэр дэвшигчдэд халтай хэмээн үзэх нийтлэг төсөөлөл залуучуудын дунд байдаг учраас залуучууд сонгуульд тэр болгон нэр дэвшихийг эрмэлздэггүй. Цаашлаад улс төрийн оролцоонд нөлөөлөх засаглалын үнэлэмжийн хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлж, улмаар залуучуудын хувьд төр засгийн тогтолцоо ард түмний дэмжлэгийг хүлээдэг гэдгийг илүү харгалзан үзэх шаардлага үлэмж нэмэгдэж байна. Энэ бол ардчилсан нийгэмд ард иргэд ямар нийгэмд, ямар засаглалын тогтолцоонд амьдрахаа шийдэх, засаглалаа үнэлэх эрх чөлөө, засаглалын үнэлэмжийг үнэлүүлсэн үзүүлэлтүүдийн цаашдын эрсдэлт нөхцөл байдлыг үнэлж дүгнэх шаардлага жилээс жилд өсөн нэмэгдсээр буй хэмээн дүгнэж болохоор байна.

Ашигласан материал

- Загджав Д. 2002. Монгол дахь иргэдийн улс төрийн оролцоо, өөрчлөлт. Уб.
Удирдлагын академи. 2016. *Залуучуудын улс төрийн оролцоо (18-35 нас)*. УА, Уб., 28 дахь тал.
- Хатанболд О. 2022. “Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцооны талаарх ойлголт.” *Шинэ толь сэтгүүл* (УТБА) 84: Уб., 78-100 дахь тал.
- Thijmen Jeroense & Niels Spiering. 2023. Political Participation Profiles. *West European Politics*, (Routledge Taylor & Francis Group) 46 (1-23; DOI 10.1080/01402382.2021.2017612): 2-3.
- Хатанболд О. 2015. Ардчилсан нийгэм дэх улс төрийн идэвх, оролцоо (Залуучуудын жишээн дээр). *Философи эрхийн судлал-XXX*, (ФСЭХ. ШУА.) Уб., 233.
- Чулуунбаатар Г., Баасансүрэн Д. ба бусад. 2017. *Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо*. ред. Д.Баасансүрэн, Г.Чулуунбаатар. Улс төр судлалын салбар, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 67-69 дахь тал.
- Мөнхбат С., Бат-Эрдэнэ Б. 2022. Монголын залуучуудын улс төрийн оролцоо: Төлөв байдал, чиг хандлага. *Социологи сэтгүүл* 15: Уб., 178-185 дахь тал.
- Загджав Д. 2002. *Монгол дахь иргэдийн улс төрийн оролцоо, өөрчлөлт*. Уб., ФСЭХ.
Удирдлагын академи. 2016. *Залуучуудын улс төрийн оролцоо*. Удирдлагын академи. Уб.,

- Хатанболд О. 2016. *Монголын ардчиллын үнэлгээ: арга зүй ба кейс*. Улс төрийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Уб., 112-113 дахь тал.
- Globalbarometer. 2023. <https://www.globalbarometer.net/>.
- Болдсайхан С. 2021. *Залуучуудын улс төрийн оролцоо гэж юу вэ, бид ямар түвшинд байна вэ?* 2 2. <https://ikon.mn/>.
- Батболд Ц. 2018. *Улс төрийн социологийн онолын үндэс*. Уб., МУИС пресс.
- Хатанболд О. 2017. *Ардчилал судлал: онол, арга зүй*. ред. Чулуунбаатар Г, Цэцэнбилэг Ц, Ганбат Д. ШУА, Философийн хүрээлэн, Соёмбо принтинг ХХК. Уб., 47 дахь тал.
- Чулуунбаатар Г., Железняков А.С, ба бусад. 2017. *Орос, Монголын залуучуудын улс төрийн идэвх, оролцоо*. ред. Г.Чулуунбаатар нар. ШУА, Философийн хүрээлэн, Соёмбо принтинг ХХК. Уб., 136-137 дахь тал.
- Болдсайхан С. 2021. *Залуучуудын улс төрийн оролцоо гэж юу вэ, бид ямар түвшинд байна вэ?* 2 2. <https://ikon.mn/>.
- UNDP. 2013. *Democratic Citizenship and Youth in East Asia. A report exploring political attitudes of East Asian youth through Asian Barometer Survey*. pp. 57-58.
- УТБА. 2012. *Азийн барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа*. Улс төрийн боловсролын академи. Уб.,
- Ганбат Д. 2010. Монгол дахь ардчиллын чанарыг үнэлэх нь: Даяаршилын нөхцөл дэх нийгэм, улс төрийн өөрчлөлт. Уб.,
- Хатанболд О. 2017. Иргэдийн төлөөллийн оролцооны институтчлэлийг тодорхойлохуй. *Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо*. ред. Чулуунбаатар Г., Улс төр судлалын салбар, Философийн хүрээлэн, ШУА. Уб., 80-82 дахь тал.